

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн төсөл хариуцсан шинжээч, Цамбалхүндэв Должинсүрэн

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалт, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
1	"Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах, сайжруулах санал боловсруулна.	Төслийн тоо /Тоо/	Засгийн газрын 2019 оны 93 дугаар тогтоолоор Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн загвар хэлэлцээрийг баталсан	"Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэн болон шинээр байгуулах саналыг боловсруулсан байна. /2 хэлэлцээрийн төсөл/	Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр"-ийг шинэчлэх болон шинээр байгуулахтай холбогдуулан байгуулагдсан хэлэлцээрүүд, зөвлөх үйлчилгээний тайлан судалгаанууд болон ирүүлсэн саналуудтай танилцан саналыг боловсруулах ажлууд хийгдсэн. Үүний хүрээнд Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улстай Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан	11-р сар, 12-р сар	100%

					хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах холбогдох судалгааг хийсэн. Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улстай хэлэлцээр байгуулахаар яриа хэлэлцээг эхлүүлсэн. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улстай байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн "Хөрөнгө оруулалт" бүлгийг боловсруулахад судалгаа хийж, санал бэлтгэн ажилласан бөгөөд 4 дэх шатны хэлэлцээг Солонгосын талтай хийсэн.		
2	Гадаадын хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг зохион байгуулна.	Гомдол шийдвэрлүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо /Тоо/	Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 413 дугаар тогтоол гарсан.	Арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, хөрөнгө оруулагчийн гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. /1 арга хэмжээ/	2023 оны Засгийн газрын Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 160, 413 дугаар тогтоолуудын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд холбогдох газруудаас хэрэгжилт авч, гомдол гаргагчид мэдээлэл өгч ажилласан. 2024 онд гадаадын хөрөнгө оруулагчдаас нийт 25 гомдол ирүүлсэн бөгөөд Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс холбогдох төрийн байгууллагуудаас тодруулга, тайлбар, мэдээлэл авах, зохих хууль тогтоомжийн	11-р сар, 12-р сар	100%

					дагуу шуурхай шийдвэрлэх талаарх холбогдох шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Нийт 108 гомдол ирснээс 26 гомдол шийдвэрлэгдсэн. Шаардлагатай гомдлуудыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан.		
3	3.1.3. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа, холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу	Хэрэгжилтийн явц /Хувиар/	-	Арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажилласан байна./100 хувь/	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу БНФУ-ын "Орано майнинг" ХХК-тай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээг боловсруулах ажлын хэсэгт тус газрын дарга Б.Анар ажилладаг бөгөөд тус гэрээг байгуулахад шаардлагатай судалгаа, мэдээллийг тухай бүр боловсруулан ажилласан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ олгуулах хүсэлтэд дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тус яамнаас байгуулахаар ажиллаж байна. Орон тооны бус зөвлөлийг байнгын болон байнгын бус нийт 17 гишүүнтэй байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд зөвлөлийн ажиллах журмын	11-р сар, 12-р сар	100%

	түүнээс дээш хувийг эзэмших зөвшөөрөл олгох асуудлыг судалж, шийдвэрлэх, үйл ажиллагаанд хяналт тавина.				төслийг боловсруулсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд уул уурхай, эсхүл банк, санхүү, эсхүл хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зорилгоор Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг эзэмших зөвшөөрөл олгуулах хүсэлтийг судалж, холбогдох байгууллагуудаас санал аван дүгнэлт боловсруулж, шийдвэрлэсэн.		
4	Хөгжлийн бодлогын баримт бичигтэй гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хүрээнд хийх арга хэмжээг уялдуулах, төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг оролцогч	Хэрэгжилтийн явц, хувиар /Хувиар/	Хэрэгжилтийн явц, хувиар /Хувиар/	Тухай бүр холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулсан байна. /100 хувь/	Шинэ сэргэлтийн бодлого, ЗГҮАХ 2024 - 2028-т туссан төслүүдийн хүрээнд гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлж гаргасан. Тус ажлын хүрээнд салбар яамд болон ОУБайгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох ажлыг тухай бүр зохион байгуулж, санал хүргүүлж ажилласан. 2024 онд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын УЦС-ын төслийн БНХАУ-ын талтай зээлийн хэлэлцээрийг байгуулах	11-р сар, 12-р сар	100%

	талуудын хамт тодорхойлох, холбогдох гэрээ, хэлэлцээрийг эцэслэн тохирч байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.				ажилд оролцсон. Мөн БНХАУ-тай холбогдох хил холболтын төмөр зам болох "Гашуунсухайт-Ганцмод", "Ханги-Мандал", "Шивээхүрэн-Сэхээ" зэрэг төслүүдийг эрчимжүүлэх, гэрээ хэлэлцээрийг байгуулах ажлын хэсэгт орж ажилласан ба бусад хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан.		
5	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлалыг шинэчлэн боловсруулна.	УХОХ боловсруулах аргачлал боловсруулах явц, хувиар	УХОХ боловсруулах аргачлалыг шинэчлэн батлуулах шаардлагатай болсон.	УХОХ боловсруулах аргачлалыг шинэчлэн боловсруулсан байна. /100 хувь/	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлалыг Японы "ЖАЙКА" ОУБ-тай хамтран 2024 оны 06 сард шинэчлэн боловсруулсан. 2024 оны 11 дүгээр сар хүртэл аргачлалын дагуу ашиглах системийн сайжруулалт, засварыг оруулан боловсруулж, ЭЗХСайдын 2024.11.19-ний өдрийн 01/2475 дугаартай албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авахаар хүргүүлсэн. 2024 оны 12 сардаа багтаан батлуулахаар ажиллаж байна. Аргачлалыг боловсруулж дууссан/100%/	11-р сар, 12-р сар	100%
6	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн явц, хувиар	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Шадар	Төсвийн хөрөнгө оруулалтаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан бөгөөд тус	11-р сар, 12-р сар	100%

төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв хийлгэх саналыг хүлээн авч, эрэмбэлэх, тодорхойлох ажлыг зохион байгуулна.		сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад тусгагдсан.	төсөв хийлгэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлагдсан байна. /100 хувь/	хуульд Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын багцад "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээ тусгагдсан. ТЭЗҮ, зураг төсөл хийлгэх төсөл, арга хэмжээний мэдээллийг авч, нэгтгэсэн бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн төслийн саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт туссан байдал, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, санхүүжилтийн эх үүсвэрийг хувийн хэвцлээр болон бусад эх үүсвэрээс санхүүжих боломж зэрэг үндсэн шалгуураас гадна бусад төсөвт өртөг, урсгал зардал нэмэгдүүлэх эсэх, газрын асуудлыг харгалзан үнэлж эрэмбэлэн, сонгон шалгаруулалт хийгдэж сонгогдсон төслүүдийн жагсаалтыг Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/12, А/22 Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын А/01, А/08, А/18, А/30 дугаар тушаалаар эцэслэх баталж жагсаалтыг Төрийн худалдан авах		
---	--	--	--	--	--	--

					ажиллагааны газарт 2024 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн 03/679, 2024 оны 05 сарын 31-ний 03/1099, 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 03/1446, 2024 оны 09 дүгээр сарын 09-ний 03/1761, 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 03/1907, 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 03/2249 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хувь 2024.12.05-ны өдрийн байдлаар 94 хувийн гүйцэтгэлтэй байна.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх.							
1	Ажлын чиг үүрэгтэй холбоотой сургалт,	Сургалт, хөтөлбөрт тухай бүр хамрагдсан	-	Сургалт, хөтөлбөрт хамрагдсан байх	Тайлант хугацаанд дор дурдсан сурталтад хамрагдаж, албан хаагчийн хувьд өөрийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарсан. 1/Хууль	11-р сар, 12-р сар	100%

	хөтөлбөрт тухай бүр хамрагдсан байх	байна. /100 хувь/		/Хувь/	зүйн ухаан доктор, Улсын дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа болон Хууль зүйн ухааны доктор, МУИС-ын ХЗС-ын багш Г.Давааням нарын "Хувийн эрх зүй дэх итгэлийг хамгаалах зарчим" сэдэвт сургалтад хамрагдаж 1 кредит тооцуулсан; 2/Хууль зүйн ухааны доктор, Хүний эрхийн үндэсний комиссын дарга Д.Сүнжид, Олон Улсын эрх зүйн докторант С.Амармэнд нарын "Үндсэн эрхийн маргааныг үндсэн хуулийн шүүхээр шийдвэрлүүлэх" сэдэвт сургалтад хамрагдаж 1 кредит тооцуулсан; 3/Хууль зүйн ухааны доктор, Улсын дээд шүүхийн шүүгч Г.Банзрагчийн "Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага" сэдэвт сургалтад хамрагдаж 1 кредит тооцуулсан.		
2	Хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлэх	Хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	-	Хувь хүний хөгжил болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	1/Удирдлагын академийн байранд зохион байгуулсан Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт 2024.05.24-ний өдөр сууж, тус хуулийн төсөлд холбогдуулан асуулт асууж, өөрийн саналыг илэрхийлсэн. 2/Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах журам, аргачлалыг танилцуулах семинарт 2024.05.10-наас 11-ний өдрүүдэд оролцож, өөрийн байр суурийг хууль зүйн талаас нь илэрхийлсэн. 3/Төрийн албаны зөвлөлийн сургалтын танхимд 2024.02.22-ны өдөр зохион байгуулсан "Захиргааны эрх зүйн	11-р сар, 12-р сар	100%

					тусгай ангийн хөгжилд хуульчдын санаачлага" сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, өөрийн байр суурийг мөн илэрхийлсэн. 4/Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хунан олон улсын бизнесийн мэргэжлийн коллежийн зохион байгуулсан "Монгол дахь Бизнесийн түвшний сургалт" сэдэвт мэргэжил дээшлүүлэх сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 04 дүгээр сарын 23-ны өдрийн хооронд оролцсон болно. Энэхүү мэргэжил дээшлүүлэх семинараар БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн ололт амжилтыг богино хугацаанд суралцаж, тус улсын ядуурлыг бууруулсан туршлага, ололт амжилт, гадаад худалдааны тогтолцооны шинэчлэл, хөрөнгийн зах зээл, нийлүүлэлтийн сүлжээний инновацын бодлого зэрэг сайн туршлагаас суралцаж, хот суурин газрын худалдааны хөгжил, хөгжлийн чиг хандлагыг судлах зорилтын хүрээнд Иву хотын олон улсын худалдааны төвд зочилж, Шанхай хот дахь олон улсын санхүүгийн төвд зочилж орчийн үеийн олон улсын худалдааны төвийн менежмент, хөгжлийн загварыг ойлгож, Чанша хотын онцлог аж үйлдвэр, хот суурин газрын худалдааны хөгжилтэй танилцаж, БНХАУ-ын ядуурлыг бууруулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүсчилсэн хөгжил, "Нэг бүс, Нэг зам" эдийн засгийн хөгжилд ашиглаж буй загвар, үйлдвэрлэл болон инновацыг хөгжүүлэхэд баримталж буй бодлого зэрэг эдийн засгийн бодлогоос		
--	--	--	--	--	---	--	--

					туршлага судалсан болно		
3	Монгол бичгийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлсэн байх	Сургалтад хамрагдсан байх	-	Сургалтад хамрагдаж анхан шатны мэдлэгтэй болсон байх	Байгуулагаас зохион байгуулж буй Монгол Бичгийн сургалт болон тус сургалтын хүрээнд Монгол бичгийг бие даан судалж байна.	11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хөгжлийн төсөл хариуцсан шинжээч, Цамбалхүндэв Должинсүрэн /...../

Огноо:

2024/12/18

